

Тамын орны зурхайн тооны язгуур

Брайн Бауманн*

Oyin-i geyigülügči neretü šastir orosibai

1950-аад оны үед Локеш Чандра (Lokesh Chandra) болон түүний аав Рагху Вира (Raghu Vira) нар Бээжингийн Орд Харшийн Номын Санд хадгалагдаж байсан Бурхан шашны холбогдолтой олон ном судруудыг хуулбарлан гаргасан байдаг. Энэ хоёр хүний гаргасан Шата Питака [Sata Pitika] ногоон цувралыг бүх монгол судлаач сайн мэднэ. Энэ цувралын ихэнх бүтээл Ганжуур, Данжуурт багтсан байдаг. Зарим нэр бүхий бүтээлүүд, жишээлбэл, Цагийн хүрд, Ааржи Бооржи гэх мэтийг тусгайлан хэвлүүлжээ. Дээр дурдсанаас бусад үнэ цэнэтэй бүтээлүүдээр *Early Buddhist Texts in Mongolian* гэдэг эмхтгэл гаргажээ.

1997 онд би энэ эмхтгэлийн *Oyin-i geyigülügči neretü šastir orosibai* [Оюуны гийгүүлэгч нэрт шастир оршвой] гэсэн бичвэрийг судалж эхэлсэн. Тус шастир сансар хорвоогийн зовлонгоос тонилохын/аврахын тухай, сансрын хүрд тамын орны товчлол агуулдаг юм. Энэ шастирыг 18-р зууны үед барлаад, анх түрүүн Жанжаа Хутагт (Jianggya Khutukhtu) Энх Амгалан (Enkhe Amugulang - Kangxi)-д өргөж байв.

Бичвэр 18-р зуунаас эрт үүссэн бололтой. Сажаба бүтээл байж бичиг үсэг эрт үеийнх гэдэг нь Их монгол улсын үеийн монгол хэлээр дүрслэгдсэнд буй. Шүлэглэн бичсэн, яруу хэмнэлтэй, мөр толгой холбож бичсэн бүтээл мөн. Маш баялаг үгийн сангай. Эртний монгол хэлний өв уламжлал хадгалагдсан үгийн сангийн доторх нийт үгийн 40 гаруй хувь дахин давтагдахааргүйгээр бичигдсэн байдаг. Үүнээс хоёр дүгнэлт хийж болно: 1. Төвд хэлнээс монголоор анх буулгасан хүн маш оновчтой орчуулжээ. 2. Энэ шастир маш өргөн сэдвийг нь хамгийн үр өгөөжтэй аргаар бичигдсэн.

Дүгнэлт хийхээс гадна үгийн сангийн баялгийн талаар бас нэг санаа авч болно. Энэ шастирын ховор үгийн дотор зарим нь зөвхөн Чойжи-Одсэр (Chosgi odser)-ийн 1312 оны Бодачирьяа-аватарагийн орчуулгад олддог аж. Чойжи-Одсэрийн Бодачирьяа-аватарагийн шүлэг найргийн уран чадвар нь энэ шастирынхтай их төстэй байна. Харин энэ шастирыг яг хэн, хэзээ орчуулсныг нь мэдэхгүй учраас цааш нь нэг зүйл ярих хэрэгтэй. 1368-аас хойш

* Индиана Их Сургууль

15-р зууны үеийн эхэнд хүртэл Монгол ном Бээжинд хэвлэгдэн гарч байжээ. Тэгэхээр энэ шастирыг бодвол 1312 оноос 15-р зууны эхэн үеийн хооронд үүссэн гэж хэлж болно.

Тоо зурхай

1997 онд би энэ шастирыг судлаад, орчуулга, галигчлал, индексийг урьдчилан бэлтгээд л, өөр сэдэв үзэх болсон. Тэр сэдэв бол тоо зурхай. Санамсаргүй тоо зурхай тамын оронд маш ач холбогдолтой буй гэж мэдсэн юм. Үнэндээ, тоо зурхай гэдгийг мэдэхгүйгээр тамын орон гэсэн сэдвийн тухай юу ч ойлгож чадахгүй байна л даа. Учир иймд, тамын орны тухайд ярихаас өмнө тоо зурхайн тухай ярьсан нь дээр.

Тоо зурхай гэж юу гэсэн үг вэ? Орчин үеийн түүх энэ нэр томъёоны утгад нөлөөлж оорчилсон нь мэдээж. Гэхдээ уг нь ямар утгатай байсныг тийм амархан мэдэх аргагүй. Нэг сэдэвт тэмдэглэдэг гэж болно. Тэгвэл ямар сэдэвт вэ? Түүхэнд үзвэл, энэ хоёр үгийг хамтад нь ер нь бичдэггүй байсан. Заримдаа зурхай бичсэн ч голдуу тоо гэж бичдэг байсан. Монгол хэлний тоо гэсэн үгээр Төвдийн *tsis* гэсэн үгийг орчуулдаг. Бурхан шашны *tsi-ba* бол Өрнөд нийгэм, ялангуяа Грек, Латин хэлнүүдийн “mathematica” гэсэн үгтэй адилаар. Үнэндээ тэр уламжлалаас гарсан шинжтэй байдаг. Эрт үеийн “mathematica” одооны “mathematics” гэхээс нэлээн өөр утгатай байсан. Одоо “mathematics” болбол, номерийн тухай бодно. Дундад зууны үед “mathematics” гэсэн үг давхар утгатай байсан юм. Нэгдүгээр нь бол, номер гэсэн үг. Тэгээд төвдөөр *tsis*, монголоор *тоо* гэж орчуулдаг байсан. Гэхдээ “mathematics” гэсэн үгийн гарлыг үзвэл, “мэдлэг” гэсэн утгатай байсан. Дундад зууны үед энэ утга нь мөн л гол утга нь хэвээрээ байжээ. Тэгээд Монголын Бурхан шашны уламжлалаар тоо гэсэн үг зүгээр л “мэдлэг ухаан” гэсэн утгатай. Англиар “knowledge” юмуу “science” гэсэн утгатай.

Тоо гэж ямар үүрэгтэй байсан гэвэл байгалийн хоосон чанарыг засах үүрэгтэй байсан. Яаж засна гэвэл, олон арга хэмжээ нь хэлж болно. Гэхдээ голдуу үүрэг бодвол цаг хугацаа орон зайн хэмжээсийг тогтоох гэж ойлгож болно. Тэгээд тооны талаар тамын орны тухай ярьвал, гурван гол зарчмыг нь ойлгох хэрэгтэй.

Гарал үүсэл

Энэ гурван гол зарчмын нэгдүгээр нь бол гарал үүсэл. Байгаль ертөнц үнэмлэхүй хоосон чанартай байна. Би үүнийг бурхан шашны номоор хэлэхгүй. Харин хөдөөний хүний нүдээр хэлж байна. Миний нутаг Монголынхтой төстэй, уудам хээр талтай газар мөн. Манайхан бол тариачин, жимс түүх, ан хийх, загас барих дуртай хүмүүс мөн. Өвөлдөө бид алгана загас нуурын мөсөөр булт татаж барьдаг. Харамсалтай нь заримдаа хүн нуурын мөсөнд нэвт унаад загасанд баригдах ч бий. Усанд орохын талаар ялангуяа машин дотор сууж байтал усанд орохдоо хүн самгардаад л живж үхэх байдал их гардаг юм байна аа. Хүн самгардах үедээ байгалийн хоосон чанараас гадна өөр харагдахгүй. Ой шугуйд арга ядан төөрвөл мод, мочир, шувуу, чулуу ялгахгүйгээр хэдий бие сайтай боловч үхэх боломж бий. Тийм учраас залуу байхад аав минь “усанд орвол газраа нэг цэгт төвлүүрч хар” гэж сургасан билээ.

Байгалийн хоосон чанарыг дийлэнхдээ баримжаа авахаар ямарваа нэгэн цэгт тогтох хэрэгтэй нь мэдээж. Надад үнэн, та нарт үнэн, бүх хүмүүст үнэн, амьтанд ч үнэн – ургамалд ч үнэн байж магадгүй. Өнөөдөр үнэн, өчигдөр үнэн байсан, маргааш үнэн байх болно. *Тоо*, “*Mathematics*”, *Мэдлэг ухаан*, “*Science*”, тийм чанартай. Хүний гарал үүслийн тухайд бол хүнийг бичнээс хувиран үүссэн гэдэг. Гэтэл үүнд дээр дурдсан чанар байхгүй. Хүн бичнээс хувиран үүссэн гэдэг бол шинжлэх ухаан. Шинжлэх ухаан мэдлэг ухаанаас арай өөр.

Ер нь ямар нэгэн баримжаалахын цэгт тогтонгуут хязгааргүй олон цэгүүд оршин байна. Гэвч иймэрхүү тоолшгүй олон цэгүүдээс оюун ухаан гарахгүй. Байгалийн орчил ялангуяа нар сарны орчлоос оюун ухаан гардаг. Оюун ухаанд цаг хугацаа гурван хэмжээст орон зай бодогдоно. Оюун ухаанаар орчлон ертөнцийн бүх юмыг нэг нэгээр харьцангуйгаар нэрлэж чадна.

Нэг хүний үнэн бол хүний нийгмийн үнэн болно. Яг одоо манай дэлхийд иймэрхүү анхны цэг бий. Англиар "*First Point of Aries*" Монголоор "*Хонь ордны анхны цэг*" гэж хэлдэг. Энэ анхны цэгийг Хиппаркус (Hipparchus) гэдэг Грек хүн тогтоосон. Хиппаркусын дараагаар Птолемигийн Алмагест гэдэг номдоо бичсэнээр энэ анхны цэг олон газарт дэлгэрсэн. Тэгэхлээр Цагийн хүрд (Kalacakra) гэсэн дандраар дамжиж, энэ анхны цэг Монголд иржээ. Одооны одон орон судлаачид баримжаа авахдаа, дээрх Хиппаркусын тогтоосон анхны цэгийг хэрэглэдэг юм байна. Тийм боловч, Хонь гэрийн анхны цэг бол хүний гарал үүслээр нь ерөөс нь үздэггүй. Яагаад тэгсэн гэвэл, олон шалтгаан бий. Нэг нь бол Хонь гэрийн анхны цэгээс илүү эрт анхны цэг байгаа. Хонь гэрийн анхны цэг болбол хаврын хугас, өдөр шөнө тэнцэх үед Хонь гэсэн одны орны түгэхтэй хамаардаг. Энэ байдал манай эриний өмнөх 1000 оны үед тэнгэрт гарсан. Манай эриний өмнөх 5 ба 6-р зууны үед 12 шар замын ордын дэг журам байгуулагдсан. Есүс Христийн үед хаврын хугас болбол Загасын гэрт орж байсан билээ. Манай эриний 1290 оны үед Бүдун (Bu-ston) Цагийн хүрд тайлбарлаж байсан. Одооноос хэдэн жилийн дараа хаврын хугас Хумхын гэрт орно. (Тэнд манай дэлхий энх тайван болно гэж найдаж буй). Гэхдээ манай эриний өмнөх 5 ба 6-р зуунаас өмнө ч, хойно ч өөр одны дэг журмуудыг ч хэрэглэж байсан билээ.

Иймэрхүү одны дэг журмуудын хамгийн өргөн тархсан анхны цэг бол "Луу тас цавчих" гэсэн домогт багтсан. Та бүхэн бүгдээрээ энэ домгийг мэднэ байх. Энэ домгийн луу бол дэлхийн хоосон чанар. Баатар нь бол Модон од, Тайсуй. Гэхдээ энд, хамгийн чухал нь, энэ баатрын цавчих зэвсэг гэж юу вэ? Энэ бол Мичид мөн. Мичид гэдэг үг Уйгар хэлний *бичи*- гэсэн үгнээс гарч "огтлох" гэсэн утгатай. Энэтхэг хэлэнд Мичид бол Кэртэг гэж хэлдэг. Кэртэг гэдэг үгийн үндэс бол *krti*-, "огтлох" гэсэн утгатай. Мичдийн тэмдэг, тонгорог, маш өргөн тэмдэглэгдсэн буй. Энэ домгийн байдал манай эриний өмнөх 2800 оны үед тэнгэрт гарсан юм билээ. Энэ үеэс өмнө өөр нэг анхны цэг байсан гэж мэднэ. Манай эриний өмнөх 5000 оны үед Луу гэсэн одны орд Египетэд тэнгэрийн туйлд бүрхэж байгаад, дараа нь цаашаа хөвж яваад хүний дэлхийг хямралд үлдээсэн буй. Гэхдээ "Луу тас цавчих" манай бичгээр мэдэгдсэн хамгийн эртний дурсгал аж. Манай дэлхийн түүхийн хамгийн эртний гарал үүсэл мөн. Энэ гарал үүслийг Монголд "Мичид тохиох" гэдэг.

Цэгийн мөн чанар тогтворгүй учраас ямар нэгэн тогтсон дэг журам, засаг үргэлжлэн байсаар байхгүй. Ямар нэгэн тогтсон дэг журам нь зүгээр л журмын шинжтэй байна, жинхэнэ журмын мөн чанар байхгүй. Үнэндээ ямар нэгэн тогтсон журам нэг л хором зуурт алга болдог. Мэдлэг ухаантай хүмүүс байгалийн тогтворгүй чанарыг сайн мэднэ. Шинэ жил ирэх болгондоо нийгмийн уламжлалын гарал үүслийн ой тэмдэглэхээр үл барам гарал үүслийг нь засаж, дахин тогтоодог буй. Шинэ жилийн шинэ гарал үүсэл болбол, шинэ жилийн шинэ гаргасан цаг улирлын бичгээр илэрхийлэгддэг байна. Үүнээс гадна ирэх шинэ өдөр болгон нь шинэ гарал үүсэл гэж үзэгдэж болно, ирэх шинэ цаг болгон, ирэх шинэ хором болгон ... тийм л буй.

Цаг хугацаа

Ямар нэгэн цэг тогтворгүй мөн чанартай гэж ойлгоод *мэдлэг ухаан / тоо*-ны хоёрдугаар гол зарчим мэдэгдэж болно. Энэ бол цаг хугацааны хооронд үнэн юм уу тодорхой юм уу ялгаа бий гэдгийг харуулна. Монгол хүн, Бурхан шашны уламжлалтай хүн, Дорно дахины хүмүүс дээрх ялгааг сайн мэднэ. Америк хүн, *Modern Science* гэсэн уламжлалтай хүн, Өрнө дахины хүмүүс харин энэ ялгааг сайн мэдэхгүй. Монгол хэлний цаг гэсэн үгийн дотор хоёр утга багтана. Нэг нь бол цагийн хугацаа, нөгөө нь учрал гэсэн утгатай. Энэ хоёрын хооронд давамгай утга нь бол учрал. Тэгээд монгол хүмүүс цагтай гэж хэлбэл, завгүй гэсэн утга илэрхийлдэг. Англи хэлний “time” гэсэн үгийн дотор цаг хугацааны ялгаа ч багтана. Гэхдээ энэ хоёрын хооронд давамгай утга бол хугацаа. Тэгээд Америк хүмүүс “I have time” гэж хэлбэл, завтай гэсэн утга илэрхийлдэг байна.

Шинжлэх ухааны талаар модон цаг усан цагтай харьцуулахаас адилхан дүгнэлт хийнэ. Нэг шулуун мөчир дээр тэнцүү хэмжээгээр зарим хэдэн цаг тэмдэглээд, усан цагаар нарны сүүдэр хэмжихдээ бүх цагийн хэмжээ нь ондоо өөр. Нэг өдрийн дараа дахиад хэмжвэл, бүх цагийн хэмжээ нь өчигдрийнхтэй адилгүй. Мөчир нь өөр нэгэн газарт босговол, бүх цагийн хэмжээ нь дахиад өөрчлөгдөнө. Түүгээр барахгүй нэг ч цаг яг тодорхой хэмжээгээр тогтож чадахгүй. Өнөөдөр хүртэл нар нь яг хэзээ гарах нь үл мэдэгдэнэ. Байгалийн учралын мөн чанар үнэндээ юм уу тодорхойдоо юм уу ямартаа ч хэмжээлшгүй. Ердийн байгалийн учралууд хэмжээтэй, хязгаартай, хугацаатай гэж санагдана. Гэхдээ хааяа заримдаа байгалийн учралын мөн чанар санагдаж, хугацаа алга болж дэлхий ертөнц байсан юм байна аа.

Мөнх

Манай гуравдугаар гол зарчимд “мөнх” гэсэн үгийн утга хамаарна. Өрнөд нийгмийн уламжлалд мөнх гэсэн үг бол үргэлжийн гандан бууршгүй чанарыг бодогдуулна. Гэхдээ цаг хугацааны ялгааг санавал, ийм тодорхойлолт байж болохгүй. Мөнх гэсэн үгийн утгыг ойлгохоор би нэг Англи хэлний уран зохиолын онислого унших дуртай. Дурдах зохиол бол Левис Карролын *Алисса гайхамигийн оронд*. Онислого тааврын шүлэг нь:

*Humpty Dumpty sat on a wall
Humpty Dumpty had a big fall
All the king's horsemen and all the king's men
Couldn't put Humpty together again.*

*Хампти Дампти хэрмэн дээр сууж
Хампти Дампти хэрмээс унаж
Хааны цэрэг, хааны сайд
Хампти Дампти-ийг эвлүүлж чадахгүй гэнэ.*

“Humpty Dumpty” бол өндөг. Хэрэм дээрх өндөг мөнхрөхгүй. Энэ дэлхийн бүх юм өндөг адил хумхийн тоос. Хорвоогийн мөн чанар мөнх бус гэж хэлж буй. Гэхдээ өндөгний хагарсан нь мөнх чанар илэрхийлдэг буй. Өндөг хагарвал дахин засаж чадахгүй, хүн нас барвал дахин амилж чадахгүй. Мэдлэг ухаан, тооны үзлээр хугацааны тухай бодвол, мөнх бус чанартай буй.

Ёс

Тэгээд одоо тамын оронд орцгооё. Цааш ярихаас өмнө нэгэн сануулга ярьсан нь дээр болов уу. Там бол жинхэнэ юм. Нүгэлтэй хүмүүс үхсэний дараа очих газар бодитой юм биш. Тамын бодит байдал амьд хүний туршлагад буй. Хүмүүс хэвийн амьдарч байтал гэнэтхэн нэг амь

өөрчлөгдөх зовлонгийн учралд таарна. Гэм буруутай юм уу гэм буруугүй ч хамаагүй. Хүний зовлон бол дараа дуусах уу, үгүй юу ч хамаагүй. Зовлон байвч дэлхий хорвоод зовлонгоос гарах арга нь байхгүй. Тийм учраас хүний зовлон мөнхрөх чанартай буй.

Хүний өөрийнх нь хувийн тамаас сонгодог тамын тухай ойлголт арай өөр буй. Энэ ялгаа хаанаас гарсан гэвэл, ямар нэгэн засаг болбол хүний хамгийн ойр дотны юмаар зохион байгуулагддаг буй. Манай төрөл, гэрлэлт, үхэл, манай үйл, бүтээл, эрүүл, манай зүүд, заяа, ёр зэрэг иймэрхүү юмаар байгуулагдсан гэсэн үг. Гэхдээ засгийн тулд ийм тийм юм хувиллагдсан гэж болох. Засгийн байдал нь газраас дээшээ гарахын оронд тэнгэрээс доошоо буудаг байна. Тэгээд улс төрийн бие нь бодвол, ус, арьс, шөрмөс байхгүй мод, алт, шороо байна. Улс төрийн зүүд хувь хүний зүүд биш. Тэгээд тийм юм хүнээс гарахгүй бол юугаар байгуулагдсан гэвэл, ёсоор байгуулагдсан гэж ойлгож болно. Ямар нэгэн тусгай ёс бол хязгааргүй биш, түүхтэй буй.

Египет

Манай тамын орны түүх бол Египетээс эхтэй буй. Тамын орны тухай олон чухал сурвалж нэг цуглуулгад агуулагдаж байсан. Үүнийг Египетийн *Үхэгсдийн ном* гэж нэрлэдэг. Энэ нэрийг 1842 онд К. Р. Лепсиус хүний нэрлэсэн юм билээ. Энэ нэр буруу байж тамын орны тухай буруу сэтгэл төрүүлдэг буй. Яагаад гэвэл, нэгдүгээрт, энэ номын дотор олон үеэс олон сурвалж бичиг байгаа, ганц нэг бүтээл биш. Энэ олон бүтээлийн нийтлэг онцлог бол эдгээр сурвалжууд фароан хийгээд язгууртан дээдсийн булшнаас олдсонд буй. Гэхдээ фароан ба үхэгсдийн хүний амьдралын тухай юу ч байхгүй. Египетийн өв уламжлалд үхлийн тухай олон сурвалж буй. Гэхдээ Египетийн *Үхэгсдийн ном* нь жинхэнэ үхлийн ёсны тухай сурвалжтай адилгүй. Египетийн *Үхэгсдийн номын жинхэнэ сэдэв* бол одон орны тухай мөн.

Одон орон

Эрт үед Египетийн тэнгэр бол гурван бүслүүрээр хуваагдсан байжээ. Дээд бүслүүр тэнгэрийн хойт хэсэгт байна. Энэ бүслүүрт тэнгэрийн туйлыг тойрох одод агуулагддаг, жишээ нь Долоон бурхан. Иймэрхүү од бол тэнгэрийн хаяаны дор буухгүйгээр / жаргахгүйгээр шөнө бүр харагдаж болно. Доод бүслүүр тэнгэрийн өмнө хэсэгт байна. Энэ бүслүүрийн одод тэнгэрийн бүслүүрийн дор буудаг, жишээ нь Тэнгэрийн хар нохой, Марал. Иймэрхүү одод буух нь байтугай жил болгон тусгай нэг үед олон хоногоор зүүн талын хаяанаас түгэхгүйгээр харагдахгүй. Дунд бүслүүр тэнгэрийн улаан замын дагуу оршдог буй. Дунд бүслүүрийн дундуур тэнгэрийн шар зам гол мөрөн шиг нар ташихын зун өвлийн хоёр туйлаас тахирлан урсдаг аж.

Египетийн жил арван хоёр сартай байсан. бүх сар гурван арав хоногтой байсан. Бүх арав хоног ямар нэгэн одод тааруулсан буй. Нарны байрлалаар үзэж, жил 365 хоногтой, гэвч одны байрлалаар 360 хоногтой байсан. Тэгээд нэг жил 36 арав хоногтой байж, 36 тусгай одтой байсан. Өдөр шөнө 18 цагаар хуваагдсан. Үүрийн үдшийн цагууд хасагдаад шөнө 12 цагтай байсан. Ямар нэгэн шөнийн 12 цагт тэмдэглэж байгаа тухайн арав хоногийн од нь арван хоногийн дараа шөнийн 11 цагт тэмдэглэгддэг байсан гэх мэт.

Энэ арав хоногийн одны дэг журам нь тэнгэрийн хамгийн тод од, Содис (Sothis), Монголоор Хар нохой гэсэн одноос үндэслэн байгуулагдсан түүхтэй. Доод бүслүүрийн нэг од жилд тэнгэрийн баруун хаяанаас жаргаад 70 орчим хоногоор далд байсаар л байдаг. 70 хоногийн дараа зүүн хаяанаас түгж гардаг. Содис гэдэг одны түгэх нь их билэгтэй сайхан учрал гэгддэг. Яагаад гэвэл, энэ одны түгэх нь Нил мөрөн үерлэх үетэй давхацдаг байжээ. Доод бүслүүрийн

бусад одууд бас 70 орчим хоногоор далд байсан түүхтэй. Энэ 10 хоногийн одны дэглэм цагаар үл барам зай ч тэмдэглэдэг байсан. Хэмжээ авахаар Египетийн одон орончид хэд хэдэн дүүжинт эгцлүүр хэрэглэдэг байсан. Иймэрхүү оосортойгоор нэг одны байрлалыг тогтоож аваад, бусад одны байршлыг харьцангуйгаар тогтоодог байжээ. Тэгээд ийм аргаар ямар од ямар цагт хаана байрлахыг яг таг тогтоодог байсан. Дэлхийн бүх үйл явдал нь тэнгэрийн одод тааруулсан учраас дэлхийн үйл явдлыг урьдчилан мэдэгдэж чадсан. Гэвч яваандаа энэ нарийн бус дэг журмыг тохируулан засах хэрэгтэй болсон. Тэгээд энэ талаар Египетийн одон оронч дөрвөн тогтсон өөрчлөгдөшгүй цэгт шүтсэн. Энэ дөрвөн цэг бол манай дөрвөн зүг байж ялангуяа улаан шар замууд жилийн хугастай тохиох зүүн баруун талын цэгүүд.

Ёгт

Иймэрхүү одон орны байдал нь ёгтоор дүрслэгдсэн буй. Гол мөрөн шиг тэнгэрийн шар зам яг гол мөрөн шиг дүрслэгдсэн юм. Дундад бүслүүр бол голын хөндий шиг дүрслэгдсэн. Энэ дундад бүслүүрийн хөндий бол хоёр уулын нуруудын дунд оршдог. Нар нь онгоц юм уу тэргийн дотор арван хоёр цагийн одоор татуулдаг. Тэнгэрийн хамгийн тод од Содис - Хар нохой бол нохой мөн – заримдаа нохой, заримдаа цөөвөр чоно. Энэ од газарт бууж далд оронд орохдоо “үхсэн” гэж хэлдэг гэнэ. Одны орд бол орд юм уу, гэр юм уу, балгас юм уу, ямар нэгэн од газарт оронгуут газрын үүдийг дайрч өнгөрнө гэж хэлдэг. Газрын доор нэг нуур байдаг, нуурын ус нь аагтай, өмхий. Заримдаа одод нулимс шиг унадаг, гаслантай учраас өмхий нуур дүүрдэг. Газартаа унаад ямар нэгэн од дөнгөнд баригддаг гэхдээ нарны гэрэл арилгаад, дахин амилна. Зүүн талын хаяаны тэнгэрийн үүдээр мандан түгээд тэнгэрийн далайд орно. Энэ орчлонд хэзээ ямагт байлдаан гарч байна. Тэнгэр газар, өдөр шөнө, гэрэл харанхуй, засаг хямрал тулалдаж байна. Тэгэхлээр зэвсэг нь жад болон бусад мэсээр тэмдэглэсэн дуу, цахилгаан, шуурга, үүл, манан гэх мэт олон юм буй. Хямрал дийлэнхдээ тэнгэр үерлэсэн гэж хэлдэг. Засаг хадгалахаар сүлд юм уу нэг мод босгоод энэ сүлд бол хэн амьдарна, хэн үхнэ гэдгийг шийднэ. Шүүхдээ амьтны сүнсний зүрх, шувууны өдийн эсрэг тэнцүүр дээр тэнцэнэ. Нүгэлтэй амьтан маргаашийг үзэхгүй, буянтай амьтан дахиад мандана. Энэ шүүхийн хэрэг бол одод хэзээ далд болохын тооцоог дүрсэлдэг. Энэ шүүхийн хэрэг шөнө дундад гардаг. Яваандаа нүгэлтэй од хилэнцээ арилгаад, зүүн талын хаяанд дахин амилна. Одны дээр нь хоёр багана юм уу ууланд бэхэлсэн чулуун хавтан тааз дээвэр бий. Энэ хоёр багана бол байрлал тогтохын эцсийн хамгийн чухал зүүн баруун зүгийг дүрсэлдэг. Энэ чулуун дээвэр бол тэнгэрийн суурь. Тэгэхлээр тэнгэр дөрвөн хэсэгт хуваагдана, энэ дөрвөн хэсэг бол дөрвөн тив. Бүх тив ханатай. Энэ дөрвөн ханыг Энэтхэг хэлэнд Махаража гэж хэлдэг. Монголоор Махранз. Өнөөдөр Чойжин ламын Музейд очвол энэ дөрвөн Махранз харагдана. Орчлонгийн дунд бол фараон. Фараон таалал төгссөний дараа ямар нэгэн од болж нартай хамт яваад хаврын хугаст зүүн хаяа руу гарахад, ой шугуйн дотор төөрсөн нялх хүүхэд болдог. Намрын хугаст баруун хаяа руу хүрч ирэхэд, ой шугуй гоё сайхан жимстэй болно. Гасланд буухын оронд диваажинд очиж жаргалтай бууна. Ёгтоос тэнгэр газар бие биедээ тольддог. Яваандаа тэнгэрийн ямар нэгэн тохиол дэлхийн тогтсон байдалд тольдохгүй бол энэ учрал нь цаг өнгөрөөд нүх рүү, тамын там руу орсон.

Иймэрхүү ёгт тус тус гарч бие биедээ зөрөлдөнө. Яагаад тэгсэн гэвэл, тэнгэрийн байдал зөрөлдөнө. Нэг хоног бодвол нар, сар, одтой харьцангуйгаар тоолж гурван зөрүү тодорхойлолт гарна. Тийм учраас ямар нэгэн тэмдэг, жишээ нь уул юм уу, гол мөрөн юм уу, ганц нэгхэн утга байхгүй, олон байдлыг дүрсэлж болох. Тэгэхлээр иймэрхүү сурвалж бичгийг эхнээс нь дуустал уншвал, нэг утга байхгүй.

Өөр уламжлалууд

Эртний Вавилонд бас тамын орны чухал уламжлал байгаа. Чухал сурвалж бичиг бол *Энума Элиш*, *Гэлгамешийн тууль*, *Инаннаагийн тамын оронд буусны тухай* гэх мэт. Энэ уламжлалд цолмон гарагийн үүрэг тодорхой үзэгдэнэ. Цолмон бол тэнгэрийн хамгийн тод гараг байж дотоод гараг учраас дүн шөнө харагдахгүй, тэгээд өглөө, оройн гараг хоёр нэртэй буй. Цолмон цав цагаан өнгөтэй гоо сайхан учраас эмэгтэй шиг дүрсэлдэг. Гэхдээ түүний улирлыг тогтоход маш хэцүү учраас садар самуун хүүхэн гэж хэлдэг. Нүгэлтэй байж тамын оронд орж Таммузтай хамт тамын орны хан хатан болдог. Таммуз бол үхсэн Тэнгэрийн нохой. Энэ хоёр тамаас мандахад, чухал баярын өдөр гардаг.

Вавилоны уламжлалд тэнгэрийн байлдаанд ялагдсан од нь тамын оронд унаад баригдсан гэнэ. Ялагдсан од бол мангас, аварга, Грек хэлээр “титан” гэж хэлдэг, Перс, Согд хэлээр “*daeua*” гэж хэлдэг, Энэтхэг хэлээр “асура” гэж хэлдэг. Вавилоны уламжлал дээр одон орны байдал нь домог үлгэр, туулиар дүрслэгддэг. Тус тус гарсан ёгт товчоолсон эхийг адагтай нь нэхээд бүхэлдээ утгатай бүтээл зохиогддог. Энэ нэхсэн чанар бол дэлхийн уран зохиолын хамгийн онцлог шинжийн нэг мөн.

Манай эриний өмнөх 8-р зууны үед Хомерийн Одиссей “Аялал” гэсэн туульд хүн, асура хоёулаа л тамын оронд буй. Гэхдээ хүн бол хагарсан өндөг шиг үхсэн зууртаа хөлдсөн юм шиг гэж дүрсэлсэн. Титан/Асура бол хүнээс дор тамын нүх, тамын там, Тартарус гэсэн газарт буй. Тэд нар дуусацгүйгээр үйл ажиллагаа явуулж буй. Гэхдээ ялагдсан учраас тэдний байх нь нэн зовлонтой.

Там гэсэн үгийн тодорхойлолт

Тэгэхээр манай сэдэв хүний үхэлтэй ёгт зүйрлэлийн маягаар хамаарсан боловч, эцэстээ одон орны сэдэв мөн. Египетэд манай ярьж байгаа далд орныг “*Duat*” гэж хэлдэг. Грек “*Hades*”, Англи хэлний “*Hell*” хоёулаа “далд” гэсэн утгатай. Монгол хэлний “там” хуучин Монгол хэлэнд “*tamu*” гэж бичдэг. Уйгар хэлэнд *tamu*. Согд хэлний *tmw* нь Хэбрэй хэлэнд “*gehenna*” гэж орчуулдаг байдаг. “*Tamu*” гэж бичихээс гадна бас “*tamuv*”, “*tamuy*” гэж нотолсон юм байна. Энэ хоёр үгийн сүүлийн -v, сүүлийн -y бол сүүлийн -s нууж магадгүй. Рамстедт энэ үгийн гарал Энэтхэг хэлний “*tamas*” ирсэн гэж бичсэн. “*Tamas*” гэсэн үг “мэдэгдэшгүй” юм уу “үл мэдсэн юм” юм уу, “мунхаг” гэсэн утгатай. Далд гэсэн утгатай адилавар. Лессинг бол Рамстедтийн дээрх гарлыг хүлээн зөвшөрсөн. Доерферийн *Türkische und mongolische elemente im Neupersischen* гэсэн толь дээр Доерфер Рамстедтийн дээрх гарлыг нь зөвшөөрөөгүй, татгалзаагүй, зүгээр оруулсан байжээ. Хэбрей хэлэнд *šāmūn* гэсэн үг мэдэгдэнэ. Энэ үг яг “далд орон” гэсэн утгатай. Энэ үгтэй хамт нэг *sēter* гэсэн үг байнга гардаг юм. *Sēter* бол “уясан, баригдсан” гэсэн утгатай. Акад хэлэнд дээрх хэлсэн *tammuz* гэсэн үг байна. Энэ үгийн утга нь тодорхой биш харин Тэнгэрийн нохой “үхэж” далд орохтой хамаатай буй. Акад хэлний *tammuz* Сумэр (Sumerian) хэлний *dumuzi* гэсэн үгээс гарсан байна. Думузигийн үхэж далд оронд орохын домог манай эриний өмнөх 3-р мянганы үед гарсан юм билээ.

Улс төрийн сурталчилгаа

Тэгээд тамын орон бодвол энэ одон орны утга хаа ч явсан хэзээ ч гээхгүй гэхдээ мэдлэг ухааны дотор тамын орны хэрэглээ яваандаа өөрчлөгдсөн ажээ. Энэ өөрчлөлт шинэ шинжлэх ухаан улс төрийн үзэлтийн дунд гарсан шинжтэй буй. Хэбрэйн Библи дотор Изаяа (Isaiah) гэсэн ном энэ шинэ үзлийг илэрхийлдэг. Байгаль орчны мөн чанар хоосон биш, дэг журам,

засагтай байна. Цаг хугацааны ялгаа байхгүй. Цаг хугацааны эх нь адгаасаа салсан юм байна. Ийм учраас уг учир шалтгаанаас эхлээд, хавтгай шулуунаар цагийн хугацаа ус шиг урсдаг гэж үздэг юм байна. Хугацааны хамгийн бага хэмжээ очир, цөмийн чанартай. Тэр цөмийн хэмжээг тогтоож чадвал, бүх одоо, ирээдүй, өнгөрсөн юм мэдэгдэнэ. Хорвоогийн бодит юмыг шүтэх хэрэггүй. Сэтгэлийн хийсвэр ухаанаар угийн шалтгаан, сэвхгүй дэг журам, төгс мэдлэгт итгэх хэрэгтэй. Хүний үзэж бодсон зүйл жинхэнэ мэдлэг биш, хүний зүүд, ёр юу ч биш. Хорвоогийн шинжилгээнээс мэдлэг авна. Иймэрхүү мэдлэг хэзээ ч хэн ч авч болно. Хүмүүс итгэлтэй бол хорвоогийн гажуу байдлыг тэгш болгож чадна. Хамгийн гол нь шударга чанар бол тэнгэрээс тогтсон хувь заяа биш. Тэгж байхаар хүн бүхэн өөрийнхөө хувь заяаг шийдэх эрхтэй байна. Бүх хүмүүс шударга сэтгэлтэйгээр хүний сайнын тулд чармайвал, энэ нүгэлтэй зовлонтой хорвоог хувиргаж чадна.

Энэ шинэ мэдлэг ухааны үзэлтэй улс төрийн шинэ үзэл ч гарсан ажээ. Энэ шинэ улс төрийн үзэл авч, төр юм уу, шашин юм уу, хязгааргүй засаг дэглэм юм уу нэг хийсвэр чанартай улс төрийн бодлого хэрэгжүүлсэн байна. Тухай үед энэ шинэ улс төрийн үзлийг дурдахад, “Бүх улсууд” гэж хэлдэг байсан. Тэр үед “бүх хүмүүс” хэлэх байсан сан бол ярьж байгаа хүний хувьд тус улсын бүх эрчүүд гэдгийг тэмдэглэх байсан билээ. Энэ хязгааргүй засгийн голдуу санаа гэвэл иргэншлийн нийгэм хадгалж байтал хөдөө байгаль орчны тэгш чанар тогтох ёстой.

Тухайн үеийн нийгэм босоо шинж чанартай байсан. Египетийн дуунд урьдын бид нар тэгш нийгэмтэй байсан ч одоо босоо нийгэмтэй болсон гэж гашуудалладаг байсан. Фараонаас боол хүртэл бүх хүмүүс хүний харьцангуй байдлыг мэддэг байсан буй. Иймэрхүү нийгэм далайн долгион шиг их хүчтэй болоод яваандаа эзэн нь нас барсны дараа мөхнө. Бүгдээрээ тэмцэж байтал, ямар ч энх тайван байхгүй. Цэрэг байхгүй бол юу ч дийлэхгүй.

Шинэ нийгэм бол үргэлжийн дуусахгүй чанартай байх ёстой. Иймэрхүү нийгэм ямар нэгэн хүнд найдахгүй, цэрэгт ч найдахгүй, бүгдээрээ тэгш тэнцүү бол энх тайвнаар амьдарна. Эхэнд нь энэ шинэ нийгэм тогтохоор хуучин нийгмийг устгах хэрэгтэй гэж бодсон юм. “Улс” гэсэн санаа “хаан” гэсэн санааг бүр устгах хэрэгтэй.

Энэ шинэ нийгмийг яаж тогтоох вэ гэвэл, хугацааны давамгай чанар нотлох хэрэгтэй. Сажа Бандида *Эрдэнийн сан субашид* гэдэг сударт ингэж буй:

Сайн ухаантан мэргэдийн хичээж бүтээсэн их хэргийг

Санаа муутай хорт хүн нэгэн цагт эвдэх буй бөлгөө

Сар жил болтол шамдан хичээж ургуулсан тариаг

Сахилт догшин мөндөр нэгэн агиинд товрог болгон мэт. (#62)

Хугацаа болохоор гарал үүслийн байрыг нь эзэлдэг. *Оюуны гийгүүлэгч нэрт шастир*-т ийн өгүүлжээ:

Өдөр шөнө хурдан нөгчсөөр

Үхэлдээ улам ойртож байтал

Өнөөдөр шинэ төрсөн гэж баясах нь

Яасан мунхаг вэ ! (22)

Би гэсэн үзэл, тачаангуй сэтгэл, хүний эрхтний мэдрэл, дэлхий хорвоо бүгдийг нь татгалзах сэтгэл төрүүлэх хэрэгтэй. Ёрын оронд ёс суртахууныг хэрэгжүүлнэ. Ёр бол аливаа юманд цаг үеэ илэрхийлдэг юм байна. Энэ бол тооны ухааны хамгийн чухал засахын арга хэмжээний нэг

нь мөн. Одооны ямар нэгэн тоо зурхайн бичиг уншвал, ёс суртахуун ерөөс байхгүй ч ёртой уламжлал хадгалагдаж байна. Ёр бол тоолшгүй, хязгааргүй агшин/цагийн мөн чанартай юм. Ёс суртахуун бий болгохоор нэг дурын номер тогтоох хэрэгтэй. Дурын номер тогтооход, бүх зүйл нэгэн нэгэн төрлөөр хуваагдана, жишээ бол, арга билиг, дөрвөн мах бод, таван мах бод, арван суртахуун гэх мэт. Тэгэхлээр хязгаартай, хугацаатай журам тогтоож чадна. Хүнийг алж болохгүй, хулгай хийж болохгүй, ханийн итгэл эвдэж болохгүй. Дурын номер байхгүй бол сайн муу байхгүй, хугацаа ч байхгүй.

Шинэ нийгэм яаж тогтоохын талаар мөнх гэсэн үгийн утга цаг мөчөөс салаад хугацаатай нийлнэ. Бүх хорвоо зөв андууршгүй, засаж чадвал хүн өтлөх хэрэггүй, үхэх хэрэггүй, хэрэм дээрх өндөг нь хагарах хэрэггүй. Алсдаа, хорвоо маань зөв зассаны дараа үхсэн амьтныг дахин амилуулна. Плато хүмүүс үнэхээр бурхан сэтгэлтэй амьтан бол бурханы цаг хугацааг мэдвэл, бурханы цаг хугацаагаар амьдарна гэж бичсэн. Үхэгсдийн доторх амьдралд сайн хүмүүс нь дахин амилна. Амьдралд муу хүмүүс тамын оронд нүгэл нь арилсны дараа дахин амьдрах юм уу, дуусашгүйгээр тамлагдах уу сайн мэдэхгүй.

Ингэхлээр хугацаа үхэлд ирээд, тамын орны үүрэг өөрчлөгдсөн юм билээ. Улс төрийн үүрэг биелүүлэх болсон. Тамын орон хүний үхэлтэй ямар ч холбоо байхгүй гэж хэлж болохгүй, гэхдээ энэ холбоо дамаар ирсэн дэмий юм байсан. Хүн нас барахад, лам нар, түүний хамаатан, тэр насанд нэг удаа нүгэл хийгээд одоо тамын оронд орсон нь за, яах вэ гэж ерөөсөө хэлдэггүй байсан юм. Их тонилгогч гэсэн сударт тамын орны тухай нэг зүйл бичсэн. Гэхдээ юуны хэрэг гэвэл, хүний сүнснийг тамын орноос чөлөөлөх зорилготой зохиосон юм байна. Тамын ороны голдуу оршин суугч бол тэрс номтон. Тамын орны гол үүрэг бол сурталчилгаа/пропаганда. Дайсан байхгүй бол тамын орны тухай ярих шаардлага байхгүй. Тамын орон нь дайсны галын эсрэг өөрийнхөө галаар тэмцэх зэвсэг байсан. Тийм учраас тамын орон болохоор богд бус, ном бус гэж үздэг юм. Тэгээд манай Оюуны гийгүүлэгч нь Сажаба бүтээл байсан боловч шар шашинд оруулсан юм л даа.

Энэ шинэтгэсэн тамын орон манай эриний өмнөх 5-р зууны Перс улсын мөхөж байх үед Ойрхи дорнодоос гарсан. Перс улсын доторх хамаарсан улс бол Египет, Вавилон, Грек, Энэтхэг, Еврей мөн. Алхандер гарсны дараа Грек эзэнт гүрэн Европын Ромыг эзэлсэн. Ромын эзэнт гүрэн Европыг эзэлсэн юм. Ром Хятадын Хан гүрэнтэй гадаад харилцаатай байсан. Энэ шинэ нийгмийн үзэл санааны дагуу хэд хэдэн хязгааргүй засаг төр буюу шашин гарсан. Нэг нь бол Католик шашин. Нөгөө нь Махаяна, Бурхан шашны Их хөлгөний дэг журам. Дараа нь Лалын шашин бас эндээс гарсан. Энэ үед ялангуяа манай эриний үед Тамын орны газарзүй, гэм, ял маш нарийн тодорхойлогдож, хийсвэр маягтай болсон. Гэхдээ тамын орон хэдий хийсвэр болсон ч дээр үеийн одон орны язгуур алдагдаагүй байсан. Тамын орны номер бол одон орны ухааны номероос эх үндэстэй байсан бөлгөө. Ихэнх нь яг Египетийн одон орны ухааныг илэрхийлдэг.

Энэтхэгт

Энэ шинэ нийгмийн хөдөлгөөний дагуу тамын орны уламжлал их өөрчлөгдсөн юм. Тухайн үеэс өмнө Энэтхэгийн тамын орон яг одон орны сэдэв байсан. Тухай үед Энэтхэгийн тамын орныг *naraka* гэж нэрлэсэн, “зовлон” гэсэн утгатай болсон юм. Манай эриний 3-р зууны үеэс Бурхан шашин, Католик шашин бие биедээ нөлөөлөх болсон байна. Урьдын дээрх хоёр нь

хоёулаа Еврей ба ялангуяа Перс уламжлалаас иш татаж байсан. Бурханы шашин бол Католик шашнаас нэг чухал ялгаа гэвэл, Их Хөлгөний Дундад Үзэлтэн хугацааны мөн чанарыг ерөөс зөвшөөрөхгүй байсан. Хорвоогийн мөн чанар бол хоосон гэж нотолсоор байна л даа. Тийм учраас Бурханы шашин яг шашин биш. Бурханы шашин дотор шашны бүх юм багтсан боловч Бурханы шашин тодорхой ёсоор мэдүүлж чадахгүй. Бурханы шашин бол мэдлэг ухаан юм уу гүн ухаан байж магадгүй.

Монгол уламжлал

Монгол уламжлалын тухай яривал Бурхан шашны үеэс өмнө тамын орны уламжлалтай байсан. Энэ уламжлал эрт үеийн одон орны уламжлал байж дээр үеийн Перс улсын уламжлалтай төстэй. Яаж төстэй гэвэл там гэсэн үг Согд хэлнээс ирсэн. Монгол Персийн уламжлалууд нь адилхан одны ордууд ёсоор шүтсэн: Тэнгэрийн хар нохой, Марал, Мичид, Долоон бурхан, Алтан гадас, бусдын тухай мэдэхгүй. Энэ хоёр уламжлал дээр тамын орон хойд зүгт оршдог. Энэ ёс нэлээн эртнийх боловч, харьцангуй шинэ уламжлал байсан. Энэ уламжлал дээр нарны гэрэл хойд зүгт тусдаггүй учраас хойд зүгийг далд орон гэж үзэх болсон. Хамгийн эрт үеийн уламжлалаар бол өмнө бүслүүрийн од далд оронд орохыг нь хамааруулдаг юм. Цаашаа Перс, Монголын уламжлалтай харьцуулбал, Перс Монгол хоёрт зуны баяр тэмдэглэдэг байсан. Энэ баяр 7 сарын 7-нд Тэнгэрийн хар нохойн түгж, Цолмон гарагтай гэрлэсний тохиолыг тэмдэглэдэг. Бурханы шашин дэлгэрэхээс өмнө Монгол нийгэм бүр дээр үеийн Эзэн гүрэн улсынхтай адилхан босоо дэг журамтай байсан. Гадаад хүн Монгол хүний дэг журмыг хараад бүр гайхсан. Монгол хаанаас боол хүртэл бүх хүмүүс хэн хэний дараа орохыг мэдэж гайхамшигтай нарийн дэг журамтай байсан. (Социалист үеэс Монгол нийгэм маш тэгш тэнцүү болсон. Тийм учраас өнөөдөр Энх тайвны гудамжинд зүүн гар тийшээ эргэхэд маш хэцүү болсон).

1250-аад оны үед Рубруккийн Виллиам Монголд явж ирсэн гэж бүгдээрээ сайн мэднэ. Тэр яагаад ирсэн гэвэл, Баг хааны хүү Сартах нь Загалмайн шашныг хүлээн авсан гэж сонссон юм билээ. Гэхдээ Сартахын Ордод ирэхдээ шинэ юм мэдэж авсан. Нэг Монгол бичигч түүнд, чи Сартах загалмайн шашныхан гэж хэлж болохгүй шүү дээ. Тэр бол загалмайн шашныхан биш, тэр бол Монгол хүн. Дараа нь Виллиам Мөнх хаантай уулзахад, Мөнх хаан түүнд, чи намайг тойн гэсэн юмуу гэж хэлсэн. Виллиам үгүй үгүй гэж хариулсан. Тэгэхлээр тэр үед Монгол хүн хязгааргүй тэгш тэнцүү засгийн тухай сайн мэдсэн боловч, иймэрхүү уламжлалыг хүлээн аваагүй байсан юм. Арваад жилийн дараа Монголд бүх юм өөрчлөгдсөн. Хубилай хаан ширээнд сууж, Чингис хааны уламжлалыг таслан шинэ замд орсон. Тэгэхлээр Ариг бөх дүүтэйгээ хэрцгий догшин дайтаж, тулалдах хэрэгтэй байсан. Түүний нийслэл нүүж Дайдуд байгуулагдсан юм. Их монгол улсыг үгүйсгэж Юань гүрэн тогтсон юм. Сажаба Пагва ламтай лам-өглөгийн эзний холбоо тогтоод энэ хоёр тэнгэр газар хоёрыг тус тус тэгш тэнцүүгээр эзлэх болсон. Иймэрхүү засаг дэлхийд маш нөлөөтэй болсон. Италийн Данте Монголын төр шашин хосолсон ёсыг хараад, Ромоос хязгааргүй засаг зохион байгуулах санаатай болоод түүний Дивинэ Комедийг зохиосон байна.